



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/166

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Сумын Засаг даргын тамгын газрын хэсэгчилсэн засвар (Гурванбулаг сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Сайжрах шилтгээн” ХХК-тай 408,927,721 (дөрвөн зуун найман сая есөн зуун хорин долоон мянга долоон зуун хорин нэгэн) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харалцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Сайжрах шилтгээн” ХХК-ийн захирал (Б.Батболд)-д даалгасугай.

3.Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Гурванбулаг сумын Засаг дарга (Б.Дэлгэр)-д даалгасугай.

4.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010217

А/166 03 Аймгийн Засаг даргын 20... оны  
 дугаар сарын ...-ны/ний өдрийн  
 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Нормчлолын сан	630,778	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	7,008,642	Ү.Бямбасүрэн
3	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	5,300,000	Ү.Бямбасүрэн
4	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	3,504,321	Ү.Бямбасүрэн
5	Магадлашгүй ажил	7,008,642	Ү.Бямбасүрэн
6	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 112 хоног	Ү.Бямбасүрэн
7	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
8	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
9	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 3 хувь	Б.Ариунболд

А/166

03 Аймгийн Засаг даргын 2026 оны  
..... дугаар сарын 05-ны /ний өдрийн  
..... дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн  
ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	Б.Мөнхэрдэнэ	Ү.Бямбасүрэн
2	Цахилгааны инженер	О.Мөнхжаргал	
3	ХАБЭА-н ажилтан	Г.Батболд	
4	Мэдээлэл холбооны инженер	Б.Батболд	
Машин механизмын жагсаалт			
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Авто кран	8690 УКМ	Ү.Бямбасүрэн
2	Ачааны автомашин	8445 УБИ	

--o00o--